### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд шуурхай, хариуцлагатай хүргэж, ардчилсан зарчмыг баримталсан, мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны байгууллага болох зорилтыг дэвшүүлсэн байна.

Монгол Улсын Засаг Захиргааны Нэгж, Түүний Удирдлагын тухай хуульд харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийн гүйцэтгэлд хяналт тавих, иргэдийн ирсэн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, мэдээллээр хангах зэрэг нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Дээрх эрхэм зорилгынхоо дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг сайжруулж, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ;
- Хууль тогтоомж журам хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг чанартай зохион байгуулж, биелэлтийг хангах, Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлж иргэдийн нийгмийн баталгааг хангана;
- Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлнэ;
- Ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, үр өгөөжийг нэмэгдүүлнэ;

- Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, усан хангамжийг сайжруулах, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, зохицуулна;
- Иргэн төвтэй хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, ногоон технологи бүхий сайн засаглалыг хөгжүүлнэ гэх зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

### 3.3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мөнххаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Мөнххаан сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх зэрэг үр дагавартай байна. Мөнххаан сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “ Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн 7,729.3 сая төгрөгийн 1.0 хувь буюу 77.3 сая төгрөгөөр тогтоов. Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн 7,729.3 сая төгрөг буюу 77.3 сая төгрөгөөр тогтоосон нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан болон хандив тусламж бусад эх үүсвэрээр 1,272.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 59.2 сая, эцсийн үлдэгдэл 476.7 сая төгрөг болж, 476.7 сая төгрөгөөр өссөн байна. *Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	59.1	476.4	417.3	99.9

Арилжааны банкны харилцах	0.1	0.3	0.2	0.1
<b>Дүн</b>	<b>59.2</b>	<b>476.7</b>	<b>476.7</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Мөнххаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 476.4 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 0.3 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна. Үүнээс:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогын үлдэгдэл 67.7 сая;
- Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл 145.9 сая;
- Эрүүл мэндийн төвийн үндсэн болон нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 7.1 сая;
- Төрийн сангийн ерөнхий орлогын (910) дансны үлдэгдэл 255.7 сая;
- Эмийн эргэлтийн сангийн арилжааны банкны үлэгдэл 0.3 сая төгрөг байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 235.4 сая, эцсийн үлдэгдэл 254.2 сая төгрөг болж, 18.8 сая төгрөгөөр өссөн байна. *Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.4	-	-0.4
Зээлийн хүүгийн авлага	4.2	3.2	-1.0
Бусад авлага	230.4	251.0	20.6
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.4		-0.4
<b>Дүн</b>	<b>235.4</b>	<b>254.2</b>	<b>18.8</b>

*Эх сурвалж: Мөнххаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд татаас, санхүүжилтийн авлага 75.3 сая төгрөг буюу 29.6 хувь, Сум хөгжүүлэх сангаас иргэн, хуулийн этгээдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл, зээлийн хүүгийн авлага 173.9 сая төгрөг буюу 68.4 хувийг эзэлж байна.

Татаас, санхүүжилтийн авлага нь тайлант онд ЭМДС-аас Эрүүл мэндийн төвд олгох 73.5 сая төгрөг, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны 1.8 сая /худгийн ажилтны хөлс олгох/ төгрөгийг дээд шатны төсөвт төвлөрүүлснээс үссэн байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 5.0 сая төгрөгийн авлага байна. Энэ нь Засгийн газраас Атрын-3 аяны хэрэгжсэнтэй холбоотойгоор тус сумын нэг иргэнд эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгосон боловч тухайн иргэн төлөөгүйгээс үүссэн байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 167.5 сая, эцсийн үлдэгдэл 189.2 сая төгрөг болж, 21.7 сая төгрөгөөр өссөн байна. *Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний	Эцсийн	Өсөлт (+),
----------	-------	--------	------------

	үлдэгдэл	үлдэгдэл	Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	18.9	22.5	3.6
Эм боох материал	20.6	20.4	-0.2
Бичиг хэргийн материал	2.5	3.4	0.7
Аж ахуйн материал	23.6	33.4	9.8
Сэлбэг хэрэгсэл	6.0	6.0	-
Түлш тослох материал	0.8	0.8	-
Хүнсний материал	0.9	3.9	3.0
Бусад хангамжийн материал	40.2	41.4	1.2
Мал амьтад	54.0	54.7	0.7
<b>Дүн</b>	<b>167.5</b>	<b>189.2</b>	<b>21.7</b>

*Эх сурвалж: Мөнххаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдэлд тайлант онд худалдан авч цар тахлын өвчний үед ашиглах халууны шил, ариутгалын бодис, хамгааллын хувцас, хэрэглэл болон аж ахуйн материал авсан нь үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Аудитаар бараа материалын дансны ажил гүйлгээтэй холбоотой 44.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 20.2 сая төгрөгийн алдааг залруулж, 24.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд*

- Худалдан авсан эм боох материал, бичиг хэрэг, нүүрс, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл зэрэг 18.7 сая төгрөгийн материалыг тайланд орлого зарлага болгохгүйгээр шууд зардалд илэрхийлсэн; /Эрүүл мэндийн төв, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, /*
- Тайланд онд зарцуулсан 17.6 сая төгрөгийн бараа материалыг /нөөцийн өвс, бичиг хэрэг, гэх мэт/ зарлагадахгүй үлдэгдлээр илэрхийлж тайлан буруу илэрхийлсэн; /Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар /*
- Бараа материалын тайланд 3.5 сая төгрөгийн эм, бэлдмэлийг нэр төрөл, тоо хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр орлого болгож зарлагадсан; / Засаг даргын тамгын газар /*
- Тусгай зориулалтын материал дансанд 4.9 сая төгрөгийн аж ахуйн материалыг эдийн засгийн ангиллаар буруу бүртгэсэн байна. /цэцэрлэг/*

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,203.8 сая, эцсийн үлдэгдэл 8,351.4 сая төгрөг болж, 1,147.6 сая төгрөгөөр өссөн байна. Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	4,727.90	5,332.4	604.50
Тээрийн хэрэгсэл	475.1	387.1	-88.00
Машин тоног төхөөрөмж	492.7	692.0	199.30
Тавилга эд хогшил	332.2	404.0	71.80
Зам, гүүрийн байгууламж	248.3	510.3	262.00
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1.5	1.5	-
Номын фонд	34.8	39.6	4.80
Бусад үндсэн хөрөнгө	812.5	905.7	93.2

Программ хангамж	4.2	4.2	-
Бусад биет бус хөрөнгө	74.6	74.6	-
<b>Дүн</b>	<b>7,203.8</b>	<b>8,351.4</b>	<b>1,147.6</b>

Эх сурвалж: Мөнххаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 170.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан бол хандив тусламж бусад эх үүсвэрээр 1,101.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна. Хандив тусламжаар ирсэн хөрөнгийг авч үзвэл:

- **Ерөнхий боловсролын сургууль:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 499.1 сая төгрөгийн спорт заалны барилга, БШУЯ-аас 4.2 сая төгрөгийн ном үнэгүй ирснийг данс бүртгэлд тусгажээ.
- **Засаг даргын тамгын газар:** Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт /ОНХС/ болон олон улсын төсөл хөтөлбөрөөр 423.3 төгрөгийн өвсний фондын хашаа, асфальтан хучилттай авто зам зэрэг хөрөнгийг бүртгэж, хүлээн авчээ.
- **Эрүүл мэндийн төв:** Эрүүл мэндийн яам, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 174.7 сая төгрөгийн рентген аппарат, хүчилтөрөгч өтгөрүүлэгч зэрэг тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй, хандив тусламжаар олгосон байна.

Ашиглах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан 124.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө актлуулах саналыг ОНӨГ-т хүргүүлж, аймгийн ИТХТ-ийн тогтоолоор данс бүртгэлээс хассан байна. Үүнд:

- ЗДТГ-ын 80.0 сая төгрөгийн дансны үнэтэй Ниссан патрол маркийн авто тээврийн хэрэгсэл;
- ЕБС-ын 20.2 сая төгрөгийн барилга, байгууламж, 8.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 8.3 сая төгрөгийн тавилга, бусад үндсэн хөрөнгө;
- ИТХ-ын 8.0 сая төгрөгийн дансны үнэтэй авто тээврийн хэрэгслийн тус тус акталсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

Аудитаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой 546.5 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс 540.1 сая төгрөгийн 5 алдаа зөрчлийг залруулж, 6.4 сая төгрөгийн 3 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 101 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна; /Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв/
- Авто тээврийн хэрэгсэл дансанд 1998 онд авсан 3.4 сая төгрөгийн Хонда маркийн 1, 2012 онд авсан 3.0 сая төгрөгийн хүлэг маркийн 3 мотоциклын ашиглалтыг хугацаа дуусаж, цаашид ашиглагдах боломжгүй, биетээр байхгүй хөрөнгө бүртгэлтэй байгаа зэрэг зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлсэн;/Эрүүл мэндийн төв/
- Харин Ньюремеди ХХК-аас худалдан авсан 9.0 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд нэр төрөл тус бүрээр нь бус бөөн дүнгээр нь бүртгэсэн;/ Эрүүл мэндийн төв/
- Үнэ төлбөргүй шилжиж ирсэн 503.2 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авснаар санхүүгийн тайланд илэрхийлсэн;/Ерөнхий боловсролын сургууль/
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 5.0 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;/ Эрүүл мэндийн төв/

- Орон нутгийн төсвөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 19.9 сая төгрөгийн зураг төсвийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн; /Засаг даргын тамгын газар/
- Үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй 3.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжид элэгдлийн зардал байгуулаагүй зэрэг зөрчлийн аудитын явцад залруулсан. /Засаг даргын тамгын газар /

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 52.0 сая, эцсийн үлдэгдэл 13.7 сая төгрөг болж, 38.3 сая төгрөгөөр буурсан байна. Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг		0.6	0.6	4.3
Байгууллагад төлөх	12.0	2.3	-9.7	16.7
Хувь хүмүүст төлөх	8.7	0.7	8.0	5.1
Дансны өглөг /ЭЭС/	31.3	10.0	-21.3	72.9
<b>Нийт дүн</b>	<b>52.0</b>	<b>13.7</b>	<b>-38.3</b>	<b>100</b>

Эх сурвалж: Мөнххаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн 72.9 хувь буюу 10.0 сая төгрөг нь Эмийн эргэлтийн сангийн өр төлбөр эзэлж байна. Төсөвт байгууллагатай холбоотой 3.6 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,258.7 сая, эцсийн үлдэгдэл 7,715.6 сая төгрөг болж, 1,456.9 сая төгрөгөөр өссөн байна. Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,208.7	1,208.7	0.0
Хуримтлагдсан үр дүн	3,386.7	4,869.6	1,482.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,663.3	1,637.3	-26.0
<b>Дүн</b>	<b>6,258.7</b>	<b>7,715.6</b>	<b>1,456.9</b>

Эх сурвалж: Мөнххаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын дансны үлдэгдэл өсөхөд тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

### 3.5.7 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 6,636.8 сая төгрөг болж өмнөх оноос 447.7 сая төгрөг буюу 7.2 хувиар өссөн байна. Орлого өсөхөд тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 47.9 сая, төсөвт байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансны орлого 323.6 сая, ЭМДС-ийн санхүүжилт 68.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тус тус нөлөөлсөн байна.

Тайлант онд улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлэг 2,324.5, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 207.3, орон нутгийн төсвөөс санхүүжих 1,677.1, ЭМДС-аас 114.5, орон нутгийн төсвийн орлогоор 611.2, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 2.6, нэмэлт санхүүжилтийн орлого 613.9, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,085.7, нийт 6,636.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

### **3.5.8 Зардлын данс**

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зарлага 5,186.5 сая төгрөг болж өмнөх оноос 758.2 сая төгрөг буюу 16.2 хувиар өссөн байна. Зардал өсөхөд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 146.5 сая төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 38.9 сая төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 9.9 сая, хангамж, бараа материалын зардал 24.6 сая, нормативт зардал 125.7 сая, эд хогшил, урсгал засварын зардал 50.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 41.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд гарсан нийт зардлаас цалин хөлс нэмэгдэл урамшлын зардалд 2,291.2 сая буюу 44.1 хувь, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 320.4 сая буюу 6.1 хувь, бараа үйлчилгээний бусад зардалд 454.5 сая буюу 8.7 хувь, урсгал шилжүүлэг 1,071.9 сая буюу 20.6 хувийг эзэлж байгаа бол байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал зэрэг бусад зардалд 1,048.5 сая төгрөг буюу 20.5 хувийг тус тус зарцуулсан байна.

**Аудитын илрүүлэлт:** Төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд аудит хийхэд зардлын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ.

#### **Төлбөрийн акт**

- ЗДТГ: албан хаагчид олгосон 0.2 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцохгүйгээр шууд зардалд илэрхийлсэн;
- ЕБС: Хөдөлмөрийн чадвараа алдсан /групп/ ажилтнаас 1.5 сая төгрөгийн ХХОАТ-ыг илүү суутгасан;
- ЭМТ: Өмнөх онуудад сумын иргэдэд ЭМГ-аас үзлэг, шинжилгээ хийлгээний төлбөр 6.1 сая төгрөгийг цалингийн төсвөөс олгож /Засаг даргын нөөц сангаас гарах/, төсвийг зориулалт бус зарцуулсан;
- СХС: Сум хөгжүүлэх сангаас ажлын байр нэмээгдүүлэх зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл авсан 2 иргэн 2.6 сая төгрөгийн зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаа, хуваарийн дагуу төлөөгүй зэрэг зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

#### **Албан шаардлага**

- ЗДТГ, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан төсвийн хэмнэлтийн горим зөрчиж, 88.5 сая төгрөгийн фитнесийн болон машин тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан;
- ЗДТГ, Эрүүл мэндийн төв цалингийн зардлаас 5.7 сая төгрөгийн ажлын хөлс олгосон, тээвэр шатахууны зардлаас 2.1 сая төгрөгийн гэрэл цахилгааны төлбөр төлж, батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллыг дагуу захиран зарцуулаагүй;
- ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналаар дэмжигдээгүй 15.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулж, санхүүжүүлсэн зэрэг зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлжээ.

#### **Зөвлөмж**

- ИТХ-ын төсвөөс сумын Засаг дарга АИТХ-д оролцох ажлаар 0.3 сая төгрөгийн томилот олгосон, мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс зардлаас 0.2 сая төгрөгийн материал худалдан авсан, **Хүүхдийн цэцэрлэг** түлш халаалтын зардлаас 0.6 сая төгрөгийн засварын материал, цэвэр бохир усны зардлаас 0.3 сая төгрөгийн модны суулгац худалдан авч, төсвийг эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулаагүй байна.
- ЗДТГ, Эрүүл мэндийн төвийн тээвэр шатахууны зардлаас 26.3 сая төгрөгийн шатах тослох материалын зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсаар иж бүрэн тайлагнаагүй байна.;
- ЗДТГ нь албан хаагчдад 2.4 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо тушаал шийдвэр гаргаагүй, Засаг даргын нөөц сангаас хүчингүй болсон эрх зүйн акт баримтлан 43.7 сая төгрөгийг зарцуулсан алдаа зөрчилд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, батлагдсан төсвийг арвилан хэмнэлт, үр ашигтай захиран зарцуулах зөвлөмжийг өгсөн байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Мөнххаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн А/25<sup>1</sup> дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлого 382.1 сая төгрөг, татварын бус орлого 46.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 564.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 131.9 хувиар давсан байна. Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>428.1</b>	<b>564.9</b>	<b>136.8</b>	<b>131.9</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>382.1</b>	<b>495.6</b>	<b>113.5</b>	<b>129.7</b>
Үйл ажиллагааны орлого	4.0	17.9	13.9	447.5
Хөрөнгийн орлого	50.0	40.7	(9.3)	81.4
Хөрөнгө борлуулсны орлого		5.8	5.8	-
Байгалийн нөөц ашигласны төлбөр		1.4	1.4	-
Бууны албан татвар	2.1	1.5	(0.6)	71.4
Бусад татвар (төлбөр, хураамж)	35.0	11.5	(23.5)	32.9
Улсын тэмдэгтийн хураамж	5.0	4.1	(0.9)	82.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3.0	0.3	(2.7)	10.0
Малын тоо толгойн албан татвар	177.0	150.9	(26.1)	85.3
Газрын төлбөр	17.0	70.4	53.4	414.1
Агнуурын нөөц ашигласны төлбөр	86.0	191.1	105.1	222.2
Ус рашаан ашигласны төлбөр	3.0		(3.0)	-
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>46.0</b>	<b>69.3</b>	<b>23.3</b>	<b>150.7</b>
Хүү, торгуулийн орлого	46.0	67.4	21.4	146.5
Ангилалдаагүй бусад орлого		1.9	1.9	-

<sup>1</sup> Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын 2021 оны төсөвт нэмэлт оруулах тухай

Орон нутгийн төсөвт төвлөрөх орлого 136.8 сая төгрөгөөр давсан нь тайлант онд ан агнуурын нөөц ашигласны төлбөр 105.1 сая, газрын төлбөр 53.4 сая төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлжээ.

Ан агнуурын нөөц ашигласны төлбөр төлөвлөснөөс давсан нь гадаадын иргэн БОАЖЯ-аас олгосон зөвшөөрлийн дагуу шонхор шувуу барьж, төлбөр төлсөн бол сумын ГЗБТ-д тусгагдсан худалдаа үйлчилгээний зориулалттай 6 нэгж талбарт дуудлага худалдаа зохион байгуулж, гэрээ байгуулсан нь газрын төлбөр давж биелэхэд нөлөөлсөн байна. Мөн үйл ажиллагааны орлого 13.9 сая, хүү торгуулийн орлого 21.4 сая төгрөгөөр давсан бол төлөвлөгдөөгүй дараах татварын орлого төвлөрсөн байна. Үүнд:

- ✓ Хөрөнгө борлуулсны татварын орлого 5.8 сая;
- ✓ Байгалийн нөөц ашигласны төлбөр 1.4 сая;
- ✓ Ангилагдаагүй бусад орлого 1.9 сая төгрөгийн орлого тус тус төвлөрсөн байна.

Харин орон нутгийн төсвийн орлогоос дараах орлого 0.6-26.1 сая төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

- ✓ Хөрөнгийн орлого 9.3 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь тайлант онд хадгаламжийн хүүгийн хэмжээ буурснаас иргэдийн хадгаламжийн хүүд ногдох татвар орлого буурсантай холбоотой байна.
- ✓ Бусад татвар 23.4 сая төгрөгөөр тасарсан нь малчдын арьс шир, ноосны урамшууллыг тайлант онд олгоогүй нь нөлөөлжээ.
- ✓ Ус, рашаан ашигласны татвар 3.0 сая төгрөгөөр тасарсан бөгөөд энэ нь ковид цар тахлын улмаас тус суманд үйл ажиллагаа явуулдаг зарим аж ахуйн нэгжүүд ажиллаагүйтэй холбоотой байна.
- ✓ Малын тоо толгойн албан татвар 26.1 сая төгрөгөөр тасарсан бөгөөд малчин болон мал бүхий иргэд татварыг цаг хугацаанд нь төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

### **Төсвийн төсөвлөлт**

Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,453.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Сумын ИТХ-ын 2021 оны А/25 дугаар тогтоолоор төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,596.3 сая төгрөгөөр баталсан байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 3,814.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3,390.7 сая төгрөгийг урсгал зардалд, 367.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 56.4 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангаас олгох зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 2,531.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,176.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 49.3 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 56.4 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого, урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 2,324.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэг, 207.3 сая төгрөг орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээс, 1,092.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 41.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 92.5 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжиж, 57.0 сая төгрөгөөр хөтөлбөр арга хэмжээг дутуу буюу санхүүжигдээгүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн урсгал зардлыг 3,296.9 сая, хөрөнгийн зардлыг 222.1 сая, эргэн төлөгдөх зээлийг 45.0 сая төгрөгөөр, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 214.2 сая төгрөгөөр илэрхийлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,564.0 сая төгрөг буюу 93.4 хувьтай байгаа нь орон нутгийн төсвийн санхүүжилт 84.7 сая төгрөгөөр дутуу, төсөвт байгууллагын зарцуулагдаагүй үлдэгдэл 34.1 сая төгрөгийг дээд шатны төсөвт төвлөрүүлж, төрийн сангийн болон эрүүл мэндийн төвийн харилцах данс 214.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй үлдсэн зэрэг нь нөлөөлж байна.

### Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ковид цар тахалтай холбогдуулан иргэн, хуулийн этгээдээс хандиваар 32.0, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 100.0, дээд шатны төсвийн захирагчаас 131.4, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 350.5, нийт 613.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, НДШ-д 89.9, хангамж бараа материалын зардалд 59.6, нормативд зардалд 168.4, эд хогшил, урсгал засварын зардалд 54.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 4.8, бараа үйлчилгээний бусад зардалд 185.2, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 41.8, нийт 603.7 сая төгрөгийг зарцуулж, 3.8 сая төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн дансанд төвлөрүүлж, 6.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Засаг даргын оруулбал зохих 129 мэдээллээс хугацаандаа оруулсан 51, хугацаа хоцроож 70 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан бол 8 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Төсвийн шууд захирагч нарын шилэн дансны мэдээллийн авч үзвэл, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мэдээллийг дутуу мэдээлсэн, өглөг, авлагын мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Тухайлбал:

- **ЗДТГ:** Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8 зарлагын гүйлгээний 210.0 сая, урсгал санхүүжилтийн 37 гүйлгээний 691.4 сая төгрөгийг мэдээлээгүй бол 34 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн;
- **Цэцэрлэг:** Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 зарлагын гүйлгээний 25.9 сая, урсгал санхүүжилтийн 35 гүйлгээний 616.1 сая төгрөгийг мэдээлээгүй
- **ЭМТ:** таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18 зарлагын гүйлгээний 157.7 сая, урсгал санхүүжилтийн 21 гүйлгээний 810.4 сая төгрөгийг мэдээлээгүй
- **ЕБС:** Урсгал санхүүжилтийн 31 ажил гүйлгээний 929.4 сая төгрөгийн мэдээллийг огт мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмжийн хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	-	-	2	-	-
Нийт дүн	2	-	-	-	2	-	-

Өмнөх оны аудитаар дотоод хяналтыг хэрэгжүүлж, төсвийн үр ашгийг дээшлүүлэх, шилэн дансны

мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээлэх талаар 2 зөвлөмжийг Засаг дарга, Санхүүгийн албаны дарга нарт хүргүүлсэн боловч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

### 3.9. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, нэг ХХК, 2 тусгай сан нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан бол эмийн эргэлтийн сан аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 2, “Хязгаарлалттай” 2 /Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн төв/ дүгнэлт өгсөн байна.

#### **Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн төлбөрийн акт, албан шаардлага**

- Орон нутгийн төсөвт төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогыг 26.1 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1<sup>2</sup>-т заалттай нийцээгүй бөгөөд ажил гүйлгээ, дансны анги, тодруулгын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.
- Засаг даргын шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд мэдээлээгүй, төсвийн төсөл, аудит дүгнэлт гэх мэт 8 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1<sup>3</sup>, 6 дугаар зүйлийн 6.4.4<sup>4</sup>, 6.4.5<sup>5</sup> дахь, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,788.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 586.6 сая төгрөгийн 12 алдааг аудитын явцад залруулж, 10.4 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 137.3 сая төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1,054.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15 зөвлөмжийг хүргүүлэв.

<sup>2</sup> хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийг үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх

<sup>3</sup> мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;

<sup>4</sup> таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

<sup>5</sup> цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

### **3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Засаг даргын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, актын төлбөрийг барагдуулах, давтан гаргахгүй байх, авлага өр, төлбөрийг бууруулах, бүртгэл тайлагналыг сайжруулах, төсвийн захирагч үр дүнг дүгнэн, хариуцлагыг дээшлүүлэх талаар анхаарч ажиллах нь зүйтэй байна.

## **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### ***Дотоод хяналттай холбоотой асуудал***

***Илрүүлэлт:*** Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, чанар хүртээмжид дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч өмч хөрөнгө, төсвийн санхүүгийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

***Эрсдэл:*** Төсвийн захирагч нар төсвийн зориулалтаар бусаар зарцуулж алдаа зөрчил нэмэгдэх

***Өгсөн зөвлөмж:*** Дээд шатны байгууллага болон эрх бүхий этгээд дотоод хяналтын журмыг батлаагүй бол Засгийн газрын 2011 оны “НИЙТЛЭГ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” 311 дүгээр тушаалын дагуу байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журмыг баталж, өмч хөрөнгө, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

### ***Орон нутгийн төсвийн орлоготой холбоотой асуудал***

***Илрүүлэлт:*** Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлдэг бууны албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, улсын тэмдэгтийн хураамж зэрэг зарим нэр төрлийн албан татвар 30.6 сая төгрөгөөр тасарсан байна.

***Эрсдэл:*** Орлого тасарч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ хэрэгжихгүй байх;

***Өгсөн зөвлөмж:*** Орон нутгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т заасны дагуу бүрэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөх;

### ***Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал***

***Илрүүлэлт:*** Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бодит үнэ цэнийн аргаар толилуулаагүй нийтлэг алдаа гарсан байна.

***Эрсдэл:*** НББ-ийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдэл зөрчигдөх;

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах;

**Илрүүлэлт:** Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна.

**Эрсдэл:** Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

**Өгсөн зөвлөмж:** Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх;

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Шалгагдагч байгууллагаар аудитаар илэрсэн алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

### 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b> 2022.03.25	<b>Аудитын нэр:</b> Мөнххаан сумын Засаг даргын тайлан	<b>Аудитын код:</b> СБА-2022/05/НА-СТА-ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b> Мөнххаан сумын Засаг дарга	<b>Сая төгрөгөөр</b>	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр

1	Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх;	-	зөвлөмж	Засаг дарга Санхүү, албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	А.Батдэлгэр Б.Эрдэнэбат
2	Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах;		зөвлөмж	Засаг дарга Санхүү, албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	А.Батдэлгэр Б.Эрдэнэбат
3	Төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.	-	Зөвлөмж	Засаг дарга Санхүү, албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	А.Батдэлгэр Б.Эрдэнэбат
4	Орон нутгийн төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.	30.6	Зөвлөмж	Засаг дарга Санхүү, албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	А.Батдэлгэр Б.Эрдэнэбат
5	Малын тоо толгойн албан татварын малчид дутуу төлсөн байна.	26.1	Төлбөрийн акт	Засаг дарга Санхүү, албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	А.Батдэлгэр Б.Эрдэнэбат
	<b>Дүн</b>	56.7			